Чандмань сумын засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай, ил тод нээлттэй, чанартай, тэгш хүргэж ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, иргэдийн эрүүл мэндийн байдлыг хамгаалах, иргэд, айл өрхүүдийн амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлэх, байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлэх зорилгоор ойжуулалтын ус хангамжийн системийг бий болгох, шийдвэрлэх
- Төрийн үйлчилгээг сумынхаа ард иргэдэд ил тод шуурхай хүргэх, амьдрах орчныг сайжруулах, аж амьдралыг дээшлүүлэх, мал аж ахуйг эрчимжүүлэх, залуу малчдыг малжуулах гэсэн олон талт үйл ажиллагаа явуулах

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Чандмань сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүү, дотоод аудитын албанаас 2020 онд Чандмань сумын ТТЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Чандмань сумын ТТЗ-ын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшнийг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Энэ нь материаллаг байдлыг үнэ цэнэ талаас нь авч үзэхийн тулд санхүүгийн тайлангийн хамгийн чухал хэсгүүд болох нийт орлогыг /өөрийн орлого, төсвийн санхүүжилт, татвар болон татварын бус орлого / сонгон авч үзлээ.

Төлөвлөлтийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаас тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нийт орлого 4578567.8 мянган төгрөгөөр 1 хувиар тооцож 45785.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 23973.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 66162.9 мянган төгрөг болж, 42189.8 мянган төгрөгөөр өсөж, төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд 66018.9 мянган төгрөг, арилжаан банкны дансанд 144.0 мянган төгрөг байршиж байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл		/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ОНХС	3,097.9	18,881.1	15,783.2	6.1
СХС	115.5	5,262.3	5,146.8	4,456.1
Төрийн сан	20,741.7	41,875.5	21,133.8	201.9
Чандмань БИТ ОНӨААТҮГ	18	144	126.0	800.0
Дүн	23,973.1	66,162.9	42,189.8	5,464.1

Эх сурвалж: Чандмань сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.2 Авлага

Авлага хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 476178.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 542376.2 мянган төгрөг болж, 66198.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл		/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	
Ажиллагчидтай холбогдсон авлага	6,100.9	8,494.1	2,393.2	
Байгууллагаас авах авлага	8,200.0	101,167.4	92,967.4	
Хувь хүмүүсээс авах авлага	3,025.9	31,276.2	28,250.3	
Зээлийн хүүгийн авлага	452,588.4	395,175.6	(57,412.8)	
Дансны авлага /ОНӨААТҮГ/	6,226.9	6,226.9	-	
Татвар, НДШ /ОНӨААТҮГ/	36.0	36.0	-	
Дүн	476,178.1	542,376.2	66,198.1	

Эх сурвалж: Чандмань сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт: Сумын ОНХС-ын хөрөнгөөр ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Сумын төвийн гэр хороололд хүүхэд залуучуудын чөлөөт амралтын талбай байгуулах ХОАОНӨГ/202001148 гэрээт ажлыг Элгэн итгэл сэтгэл ХХК гүйцэтгэсэн боловч ажлын гүйцэтгэлийн, явцын анхан шатны баримтын бүрдэл хангаагүй шууд санхүүжилт олгосон, ажлыг ашиглалтад хүлээлгэн өгөх комисс ажиллаагүй, хүлээж аваагүйтэй холбоотой 71779.3 мянган төгрөг, мөн Чандмань сумын иргэн М.Жанчивдулам 2020 оны 04 дүгээр сарын 06-нд 01 тоот гэрээ байгуулан Жаргалант багийн нутаг Хуурай харгана гэдэг газрын богино яндант худгийг засварлах ажлыг хугацаандаа гүйцэтгээгүй, гэрээг ковидтэй холбоотой сунгасан 1890.0 мянган төгрөг, Тэмүүлэх гал ХХК нь 2020 оны 06-р сарын 03-нд ХОАОНӨГ/202001065 тоот гэрээгээр Чандмань сумын сүлжээ багт моторт завь нийлүүлэх гэрээ хэрэгжээгүй, урьдчилгаа 20000.0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэн нь ковид цар тахалтай холбоотой 2021 он гарч нийлүүлэгдэж байгаатай холбоотойгоор авлага өссөн байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 395175.6 мянган төгрөгийн авлагын 321175.6 мянган төгрөг нь СХС болон Чандмань хөгжүүлэх сангийнх, малжуулах төсөл хөтөлбөртэй 74000.0 мянган төгрөгийн авлага байна.

Нийт авлагын дийлэнхийг сум хөгжүүлэх болон Чандмань хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага эзэлж байгаа бөгөөд оны эхэнд 378588.4 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 28380.0 мянган төгрөгийн зээл олгож, 33518.0 мянган төгрөгийн зээл, зээлийн хүү эргэн төлөгдөж, өмнөх онд зээлийн хүү, алданги 41503.5 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн тэй холбоотой залруулга хийгдэж, оны эцэст 321925.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Сум хөгжүүлэх сангаас 2011-2018 онуудад олгосон 31 зээлдэгчтэй холбогдох 93374.8 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага байгаа нь сангийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, 7354.9 мянган төгрөгийн, 4 зээлдэгч нас барсан байна.

Хүснэгт №3. Урьдчилгаа дансны үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	24,940.0	39,409.2	14,469.2
Цалингийн урьдчилгаа	450.0	500.0	50.0
Дүн	25,390.0	39,909.2	14,519.2

Эх сурвалж: Чандмань сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа данс өмнөх оноос 14519.2 мянган төгрөгөөр өсөж оны эцэст 3909.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь дараа онд барагдуулах боломжтой авлага байна.

Аудитын илрүүлэлт:

- 2020 онд сумын 6 багт гар худаг засварын ажил 2 удаа тендер зарлагдаж оролцогч ирээгүй, хүйтний улирал эхэлснээс шалтгаалан иргэд малчидтай шууд гэрээ байгуулсан, наадмын талбайн тохижилтод 2954.5 мянган төгрөгөөр сандал авах ажилд урьдчилгаа санхүүжилт олгогдсонтой холбоотой авлага өссөн байна.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 116185.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 140112.6 мянган төгрөг болж, 23927.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал			-
Эм боох материал	7,471.5	12,854.1	5,382.6
Бичиг хэргийн материал	2,209.9	3,714.6	1,504.7
Аж ахуйн материал	49,374.2	72,024.9	22,650.7
Сэлбэг хэрэгсэл	1,188.0	998.0	(190.0)
Түлш, шатах тослох материал	2,432.2	2,452.2	20.0
Барилгын засварын материал	-	1,064.1	1,064.1
Хүнсний материал	17,902.9	10,512.9	(7,390.0)
Бусад хангамжийн материал	18,931.5	18,311.8	(619.7)
Мал амьтад	16,675.0	18,180.0	1,505.0
Дүн	116,185.2	140,112.6	23,927.4

Эх сурвалж: Чандмань сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, ЗДТГазар тус тус өссөн, тайланд онд 10039.1 мянган төгрөгөөр хандив, үнэ төлбөргүйгээр бараа материал нэмэгдэж 166296.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 7199681.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 8368362.4 мянган төгрөг болж, 1168680.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	4,638,338.9	5,674,502.1	1,036,163.2
Тээврийн хэрэгсэл	290,108.7	316,870.9	26,762.2
Машин тоног төхөөрөмж	897,161.6	936,802.7	39,641.1
Тавилга эд хогшил	380,059.0	409,691.5	29,632.5
Түүх соёлын дурсгалт зүйл	35,450.0	35,450.0	-
Зам гүүрийн байгууламж	542,380.2	542,380.2	-
Номын фонд	50,054.4	52,141.2	2,086.8
Бусад үндсэн хөрөнгө	206,028.7	239,468.7	33,440.0
Программ хангамж	5,378.5	6,333.5	955.0
Бусад биет бус хөрөнгө	154,721.6	154,721.6	-
Дүн	7,199,681.6	8,368,362.4	1,168,680.8

Эх сурвалж: Чандмань сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвөөс 39197.0 мянган төгрөгийн бэлтгэсэн, үнэ төлбөргүй хандиваар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1185259.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 25302.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 16658.9 мянган төгрөг болж, 8643.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн				
Ажилчидтай холбогдсон өглөг	870.2	2580.9	1710.7	296.6
Бараа үйлчилгээний зардлын өглөг	8855.3	3840.7	-5014.6	43.4
Дансны өглөг /ОНӨААТҮГ/	9287.1	9287.1	0.0	
Байгууллагад төлөх өглөг	6289.6	950.2	-5339.4	15.1
Нийт дүн	25302.2	16658.9	-8643.3	65.8

Эх сурвалж: Чандмань сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд байгаа өр төлбөрийн 55.7 хувь буюу 9287.1 мянган төгрөг нь Чандмань БИТ-тэй холбоотой олон жил дамжсан, үйл ажиллагаа явагдахгүй байгаа тул барагдах боломжгүй байна.

Хүснэгт №7. Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -

Бусад урт хугацаат өр төлбөр /ОНӨҮГазар	15000.0	15000	0.0
Нийт дүн	15000	15000.0	0.0

Эх сурвалж: Чандмань сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт: Чандмань БИТ-д 2011 онд сум хөгжүүлэх сангаас 15000.0 мянган төгрөгийн зээл олгогдсон тус ОНӨҮГазар нь татан буугдсан урт хугацаат өр төлбөрийг төлөх боломжгүй байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6017502.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 7073597.3 мянган төгрөг болж, 1056095.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 8. Засгийн газрын хувь оролцоо	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,418,049.9	2,418,049.9	-
Хуримтлагдсан үр дүн	1,614,800.3	2,671,981.7	1,057,181.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,984,652.0	1,983,565.7	(1,086.3)
Дүн	6,017,502.1	7,073,597.3	1,056,095.2

Эх сурвалж: Чандмань сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 1983565.7 мянган төгрөгөөр буурсан нь 2010 онд дахин үнэлэгдсэн хөрөнгө акталсантай холбоотой, хуримтлагдсан үр дүн 2671981.7 мянган төгрөг болж 1057181.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 1092403.6 мянган төгрөгийн ашигтай ажиллаж, бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансанд СХС-ийн алданги, хүүг өмнөх онд зөрүүтэй тооцсоноос шалтгаалан бүртгэгдсэн 41503.5 мянган төгрөгөөр алдааны, төсөвт байгууллагууд хөрөнгө акталсан холбоотой өмнөх үр дүн рүү 6283.3 мянган төгрөг нийт -35220.2 мянган төгрөгөөр нягтлан бодох бодлогын залруулга хийгдсэн байна.

3.5.10 Орлогын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар татварын орлого 19841.5, тусгай шилжүүлгийн санхүүжилт 157748.1, аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 162441.2, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого 2142.9, орон нутгаас олгох санхүүжилт 167649.1, үнэ төлбөргүй орлого 665134.1, нэмэлт санхүүжилтийн орлого 167649.1, ЭМДСангаас 7881.2 мянган төгрөгөөр өссөн, татварын бус орлого 28958.7, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих орлого 840.1 мянган төгрөгөөр тус тус буурчээ.

Хүснэгт № 9 Нийт орлогын гүйцэтгэл	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,278,612.6	4,578,567.8	1,299,955.2
Татварын орлого	54,712.0	74,553.5	19,841.5
Татварын бус орлого	38,404.0	9,445.3	(28,958.7)
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	549,514.1	1,214,648.2	665,134.1
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,385,424.2	1,543,172.6	157,748.4
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	511,335.7	678,984.8	167,649.1
Нэмэлт санхүүжилтийн орлого	119,203.7	266,119.3	146,915.6
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	130,247.4	129,407.3	(840.1)

**Чандмань сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Орон нутгийн төсөвт байгууллага төвлөрүүлэх шилжүүлэг	400.0	2,542.9	2,142.9
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	467,564.3	630,005.5	162,441.2
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21807.2	29688.4	7,881.2

3.5.11 Зардлын данс

Нийт зардал өмнөх оноос 679998.6 мянган төгрөгөөр буюу 24.3 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал шилжүүлгийн зардлууд тус тус өссөн, нормативт зардал, томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, хангамж, бараа материалын зардал, хөрөнгийн зардлууд буурсан байна.

Хүснэгт № 9 . Зарлагын гүйцэтгэл

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		2,795,449.4	3,475,447.8	679,998.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,362,071.0	1,577,497.7	215,426.7
2102	Ажил олгогчоос даатгалд төлөх	175,631.6	193,465.0	17,833.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,934.3	199,506.1	68,571.8
2104	Хангамж, бараа материалын зардал	66,880.6	60,009.3	(6,871.3)
2105	Нормативт зардал	120,658.4	98,883.2	(21,775.2)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,019.6	5,194.1	174.5
2107	Томилолт, зочны зардал	10,671.0	3,929.9	(6,741.1)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	32,820.5	27,847.2	(4,973.3)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	275,875.2	477,946.1	202,070.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	533,257.1	770,234.3	236,977.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	81,630.1	60,934.9	(20,695.2)

Аудитын илрүүлэлт:

- Ерөнхий боловсролын сургууль онцгой нөхцөлийн бараа материал, ариутгалын бодис, хүнс тэжээлийн тусламж, шатахуун үнэнд 4902.8 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч зарцуулалтыг хянан баталгаажуулаагүй байна

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Чандмань сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 8/07 дугаар тогтоолд Чандмань сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 39319.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 61991.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 157.8 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 10 . Сумын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Орлогын ангилал	2020 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	

	39,319.00	61,991.19	(22,672.19)
Нийт орлого ба тусламжийн дүн	39,319.00	61,991.19	(22,672.19)
Татварын орлого	39,319.00	61,991.19	(22,672.19)
Орлогын албан татвар	15,700.00	34,611.25	(18,911.25)
Хувь хүний орлогын албан татвар	15,700.00	34,611.25	(18,911.25)
Үйл ажиллагааны орлого	1,000.00	4,064.80	(3,064.80)
Шууд бус орлого	14,700.00	30,546.45	(15,846.45)
Хөрөнгийн албан татвар	18,424.00	22,371.79	(3,947.79)
Бууны албан татвар	924.00	900.00	24.00
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	17,500.00	21,471.79	(3,971.79)
Бусад татвар, телбер, хураамж	5,195.00	5,008.14	186.86
Бусад нийтлэг телбер, хураамж	3,525.00	2,089.93	1,435.07
Улсын тэмдэгтийн хураамж	1,960.00	824.43	1,135.57
Тигээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	500.00	400.00	100.00
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,065.00	865.50	199.50
Газрын телбер		1,534.91	(1,534.91)
Газрын телбер	-	1,534.91	(1,534.91)
Байгалийн нөөц ашигласны телбер	1,670.00	1,383.30	286.70
Ан амьтны нөөц ашигласны телбер		1.50	(1.50)
Ус, рашааны нөөц ашигласны телбер	1,070.00	1,000.00	70.00
Байгалийн ургамлын нөөц ашигласны телбер	600.00	381.80	218.20

Эх сурвалж: Чандмань сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2724193.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2724193.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 119509.1 мянган төгрөгөөр бууруулж 2604684.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 2420360.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2298165.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 122195.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1543172.6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих, 811771.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 32505.0 төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлого, 29698.2 мянган төгрөгийг ЭМД-ийн сангаас, 3213.4 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр тусгай шилжүүлгээс 1495562.1, орон нутгаас 805304.7, ЭМДС-аас 29688.4, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 2487.5, туслах үйл ажиллагааны орлого 34268.0, өмнө оны авлагаас 775.8, мянган төгрөг нийт 2368086.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орон нутгийн төсөвт 2344.6, аймгийн төсөвт 47808.9 бүгд 50153.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №.11. Санхүүжилтийн төлөвлөгөө,
гүйцэтгэл

/мянган төгрөг/

Чандмань сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Д/д	Байгууллагын нэр	Нийт төлөвлөгөө			Гүйцэтгэл			Зөрүү	Тайлбар
		Санхүүжилт	Өөрийн орлого	нийт	Санхүүжилт	өөрийн орлого	Нийт		
1	ЗДТГ	386,721.1	605.0	387,326.1	383,895.6	988.5	384,884.1	(2,442.0)	татан төвлөрүүлсэн
2	ИТХ	57,509.5	-	57,509.5	57,509.5	-	57,509.5	-	
3	Сум хөгжүүлэх сан		30,115.5	30,115.5		34,293.8	34,293.8	4,178.3	2020 оны төсвийн тодотголоор орлогын төлөвлөгөөг бууруулж баталсан
4	ОНХС	122,195.2	-	122,195.2	119,097.3	750.0	119,847.3	(2,347.9)	
	ОНБ-дын дүн	566,425.8	30,720.5	597,146.3	560,502.4	36,032.3	596,534.7	(611.6)	
5	ЕБСургууль	983,491.0	1,600.0	985,091.0	959,727.9	1,200.0	960,927.9	(24,163.1)	татан төвлөрүүлсэн
6	Хүүхдийн цэцэрлэг	335,806.3	-	335,806.3	310,797.2	-	310,797.2	(25,009.1)	татан төвлөрүүлсэн
7	ЭМТөв	424,928.1		424,928.1	424,373.9		424,373.9	(554.2)	
8	Соёлын төв	77,088.8	300.0	77,388.8	75,153.8	299.0	75,452.8	(1,936.0)	зарцуулалтын эрх хаагдсан
	ТЗШ дүн	1,821,314.2	1,900.0	1,823,214.2	1,770,052.8	1,499.0	1,771,551.8	(51,662.4)	
	Нийт дүн	2,387,740.0	32,620.5	2,420,360.5	2,330,555.2	37,531.3	2,368,086.5	(52,274.0)	

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 37531.3 мянган төгрөгөөр бүрдүүлж, батлагдсан төсвөөс 4910.8 мянган төгрөгөөр илүү бүрдүүлсэн сумын ИТХ-ын 2020 оны 9 дүгээр сарын 23-ны 4/02 тоот тогтоолоор СХС-гийн зээлийн эргэн төлөлт, Соёлын төвийн өөрийн орлогод тодотгол хийгдсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 17 төсөл, арга хэмжээнд 122195.2 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 104064.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 18881.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2347156.5 мянган төгрөг нь 97 хувьтай байгаа нь ОНХС-ийн төсөл арга хэмжээний хүлээн аваагүй ажлуудын санхүүжилтийг олгоогүйтэй холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Онцгой байдлаас Ковид-19 цар тахлын зардал, статистикийн судалгааны зардал, Онцгой байдлаас томилолтын зардал, ОНХСан, Хөшөөт хөгжлийн сангаас нэмэлт орлогын дансанд 266377.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

<i>Хүснэгт № 12 . Нэмэлт данс</i>				<i>/мянган төгрөг/</i>
	Бусад орлого	Нийт		
1	ЗДТГ	251,743.4	251,743.4	ОНХС хөрөнгө оруулалт, хүн амын тооллого судалгааны зардал
3	ЕБСургууль	500.0	500.0	БСУГ -аас 500.0 төгрөг
5	ЭМТ	14,134.4	14,134.4	ЭМГ -аас эм бэлдмэлийн үнэ, сорьц тээврийн зардал
	Нийт дүн	266,377.8	266,377.8	

Үүнээс үндсэн цалин, шимтгэлд, хангамж бараа материалын зардал, эм эмнэлгийн хэрэгсэл авах зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, бусад бараа үйлчилгээний зардалд зарцуулсан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 144 мэдээллийг хугацаанд нь, 34 мэдээллийг хугацаа хоцроож, оруулах хугацаа болоогүй 2 мэдээлэл, дараа жилийн төсвийн төслийн мэдээллийг байршуулаагүй байна.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид албан шаардлага өгөгдөөгүй, 84137.7 мянган төгрөгийн 3 алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт 71 хувьтай хэрэгжсэн байна.

Хүснэгт 13. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	3	84,137.7	2	60,008.2	1	24,129.5	71%
Нийт	3	84,137.7	2	60,008.2	1	24,129.5	

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 3 тайланг түүвэрт хамруулсан байна.

Хүснэгт №14. Аудитад хамрагдсан хэлбэр, аудитын дүгнэлт

№	Байгууллагын ангилал, нэр	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр			Аудитын дүгнэлт	
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Гэрээгээр хийлгэсэн	Зөрчилгүй	хязгаарлалттай
1	ЗДТГ	1		1	1	
2	Төсвийн шууд захирагч	ИТХ		1		
3		Сургууль	1			1
4		Цэцэрлэг	1			1
5		Соёлын төв	1			1
6		ЭМТөв	1			1
7	ОНТС	СХС		1		
8		ОНХС		1		
Дүн		5	3	1	3	2

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-3, “Хязгаарлалттай” 2, нийт 5 дүгнэлт гаргасан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа, зөрчил:

Аудитаар нийт 34300.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2000.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 4000.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- ОНХС-ийн санхүүгийн тайланд авлага дутуу, тайлант үеийн үр дүнг 2000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлснийг залруулга хийсэн.

Төвлөрүүлсэн захирагчид 34300.0 мянган төгрөгийн алдаа, 1 төлбөрийн актаар 600.0, 28300.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 4000.0 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 2 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Хүснэгт № 15.		ТТЗ-ийн тайланд илэрсэн алдаа						/ мянган төгрөг /					
№	Байгууллагын ангилал, нэр	нийт илэрсэн алдаа						Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
		нийт илэрсэн алдаа		Үүнээс залруулсан		Залруулаагүй		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	ТТЗ	1	-			1							1
2	ОНХС	5	34,300	2	2,000	3	32,300	1	600	1	27,700	2	4,000
	Дүн	6	34,300.0	2	2,000.0	4	32,300.0	1	600	1	27,700	3	4,000

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Аудитаар 32300.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 600.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 27700.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага шилжүүлээ. Үүнд:

1. сумын ОНХС-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар төсөвт байгууллагын хөтөлбөр зардлаас тушаал шийдвэргүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, зарцуулалтад тавих дотоод хяналт сул зэрэгтэй холбоотой 600.0 мянган төгрөгийн шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 14 дүгээр зүйлийн 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ" Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 60 дугаар зүйлийн 60.3.6-д "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Чандмань сумын ОНХС-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар ажил гүйцэтгүүлэхдээ ажлын гүйцэтгэл тооцдоггүй, явцын мэдээ, олгосон төсвийн гүйцэтгэлийг хянадаггүй, урьдчилгаа санхүүжилтийг өндөр дүнгээр олгодог, эрэмбэлэгдээгүй 7 ажил хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлсэн, ЗД-ын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас сумын ЗДТГ-ын автомашинд сэлбэг авч зориулалт бусаар зарцуулсан, төсөвт байгууллагын хөтөлбөрийн зардлаас тушаал шийдвэргүй, анхан шатны баримтгүй ИТХ болон Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл ажиллагааны сэтгүүл хэвлүүлсэн зэрэг 27700.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 60 дугаар зүйлийн 60.3.6-д "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", Сангийн сайдын 2018 оны 228 тоот тушаалын 3.11.3-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх", 3.1.4-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт,

хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад сум, дүүргийн төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг заавал багтаах”, 3.1.2-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;”, гэсэн хуулийн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага бичих

Төвлөрүүлсэн захирагчид 4000.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 2 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн алдаа, зөрчил

Чандмань сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 345906.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 210037.8 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 135868.7 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 17004.1 мянган төгрөгийн 6 алдаа зөрчилд төлбөрийн акт, 51509.0 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд албан шаардлага, 67355.6 мянган төгрөгийн 15 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 16. ТШЗ-ын нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчил, шийдвэрлэлт /мянган.төгрөг/

№	Байгууллагын ангилал, нэр	нийт илэрсэн алдаа		Үүнээс залруулсан		Залруулаагүй		
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	
1	Төсвийн шууд захирагч	ЗДТГ	9	59,426.6	4	31,841.6	5	27,585.0
2		ИТХ	-	-				
3		Сургууль	12	76,859.1	4	6,628.4	8	70,230.7
4		Цэцэрлэг	7	46,286.9	3	32,546.5	4	13,740.4
5		Соёлын төв	1	-			1	
9	ЭМТөв	12	163,333.9	8	139,021.3	4	24,312.6	
	Дүн		41	345,906.5	19	210,037.8	22	135,868.7

№	Байгууллагын ангилал, нэр	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт						
		тоо	дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	
1	Төсвийн шууд захирагч	ЗДТГ	5	27,585.0	1	358.0	1	20,148.2	3	7,078.8
2		ИТХ	0	-						
3		Сургууль	8	70,230.7	2	8,245.9	1	31,360.8	5	30,624.0
4		Цэцэрлэг	4	13,740.4	3	8,400.2			3	5,340.2
5		Соёлын төв	1	-						
9	ТБӨӨААН	ЭМТөв	4	24,312.6					4	24,312.6
	Дүн		22	135,868.7	6	17004.1	2	51509	15	67,355.6

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар сумын ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт зарцуулалт, хэрэгжилтийг авч үзэх шаардлагатай байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Үндсэн хөрөнгө бүртгэхтэй холбоотой асуудал

- 1.1. **Илрүүлэлт:** Сумын ОНХС-ийн хөрөнгөөр 4000.0 мянган төгрөгөөр сургуулийн хөгжмийн зэмсэг бэлтгэсэн тухайн байгууллага санхүүгийн тайланд данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан зөрчил илэрлээ.
- 1.2. **Эрсдэл:** Хөрөнгө данс бүртгэлд тусгаагүй байх, хөрөнгө дутах, эзэнгүйдэх
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Сангийн сайдын 2016 оны 388 тоот тушаалаар "төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.33 (в)-д " ... хандивын хөрөнгийг бэлтгэхдээ хөрөнгийн зах зээлийн үнийг ашигладаг, хандиваар авсан хөрөнгийг зах зээлийн үнээр нь ДТ-үндсэн хөрөнгө, КТ- Орлого ", гэж заасны дагуу сургууль уг хөрөнгийг данс бүртгэлд тусгах
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

2.1 . Дотоод хяналт, тооллого хийх тооцоо бодож баталгаажуулахтай холбоотой асуудал

2.1.1. Илрүүлэлт: Сумын ЗДТГазар, ЕБСургууль, Цэцэрлэг, ЭМТөвүүдийн анхан шатны баримтуудын бүрдүүлэлт хангалтгүй, жилийн эцэст бараа материал, хөрөнгөд тооллого хийгээгүй, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, Төрийн сангаас байгууллагуудын гаргаж байгаа ажил гүйлгээний утга, зардлын зүйл анги эдийн засгийн ангилал зөрчсөн сумын хэмжээнд дотоод хяналт хэрэгжүүлээгүй дутагдал илэрлээ.

2.1.2. Эрсдэл: Дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх, дотоод хяналтын баг томилоогүй байх

2.1.3 Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 70 дугаар зүйлийн 70.2.2-д "түүхий эд, материал, түлш, сэлбэг, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ", Засгийн газрын 311 дүгээр тогтоолын 1.5-д "энэ журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө", 3.5-д "дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд 1 доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ", 3.6-д "дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ" байгууллагын дотоод журмын 4-ийн 4.16-д "Байгууллага дотоод хяналт шалгалтыг хамт олны хурлаар хэлэлцэж, байгууллагын даргын тушаалаар батлагдсан /дотоод хяналт шалгалтын журмын дагуу зохион байгуулна. 4.17. Байгууллагын даргын шийдвэрээр орон тооны бус байнгын дотоод хяналт шалгалт хариуцсан ажилтан томилно. 4.18. Дотоод хяналтын шалгалтын ажилтанд хийсэн ажлын үр дүн, идэвх санаачилга, илрүүлсэн зөрчил зэргийг харгалзан үндсэн цалингийн 10-20 хувь хүртэлх хувийн урамшуулал улиралд нэг удаа олгоно" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах, хөрөнгийн болон бараа материалын тооллого хийх, үлдэгдлийг баталгаажуулах, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэн хамт олонд мэдээлэх

2.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 15-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.
Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

АУА-202178

Аудитын
нэр:

Чандмань сумын ТГЗ-ын 2020 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын код:

2020

ХОА-2021/09/СТА-ТТЗ

Шалгагдсан
байгууллагын нэр:

Чандмань сумын Засаг дарга

Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	ОНХС-ийн санхүүгийн тайланд авлага дутуу , тайлант оны үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн	2000.0	Залруулга хийх	Засаг дарга, нягтлан бодогч	З.Онолбаатар Б.Цэвэлмаа
2	Сумын ОНХС-аас 2020 онд эрэмбэлэгдээгүй 7 ажил хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлсэн, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж ажилд урьдчилгаа санхүүжилтийг өндөр дүнгээр олгодог, ажлын гүйцэтгэл, явцын мэдээг хянасан талаар анхан шатны баримт дутуу, ИТХ-ийн төлөөлөгчдийг чадавхжуулах хөтөлбөр арга хэмжээ хэрэгжүүлсэн, ТЭЗҮ, зураг төсөв, захиалагчийн хяналтын зардал, чанарын баталгаат барьцааны тооцоог хийгээгүй , ЗД-ын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас ЗДТГ-ын автомашинд сэлбэг авч зориулалт бусаар зарцуулсан	27700.0	Албан шаардлага	Засаг дарга, Санхүүгийн албаны дарга	З.Онолбаатар С.Цэрэнханд
3	ОНХС-ийн хөрөнгөөр ЕБСургуулийн хөгжмийн зэмсэг бэлтгэсэн тухайн байгууллага хөрөнгөд бүртгэж аваагүй санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан	4000.0	Зөвлөмж өгөх	ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	З.Онолбаатар С.Цэрэнханд
4	Төсөвт байгууллагын хөтөлбөр зардлаас тушаал шийдвэргүй, анхан шатны баримтын бүрдэлгүй Сумын ИТХ болон Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл ажиллагаатай холбоотой сэтгүүл хэвлүүлсэн зөрчил	600.0	Төлбөрийн акт	Засаг дарга, санхүүгийн албаны дарга	З.Онолбаатар С.Цэрэнханд
5	Дотоод хяналт хэрэгжүүлээгүй	0	Зөвлөмж өгөх	Засаг дарга, санхүүгийн албаны дарга	З.Онолбаатар С.Цэрэнханд
	Дүн	34300.0			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР